



TSX:ERD | MSE:ERDN

ӨНДӨР АГУУЛГА БҮХИЙ АЛТНЫ ШИНЭ ДҮҮРГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ НЬ ХӨНДИЙ АЛТНЫ ТӨСӨЛ

2020 оны 3-р улирал



@ErdeneRes



@ErdeneResource



Erdene Resource Development Corp.



www.erdene.com

УРЬДЧИЛСАН ТААМАГЛАЛ: Уг танилцуулга нь урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь дараах үгсээр тодорхойлогдоно. Үүнд: (урьдчилсан сэрэмжлүүлэх), (төлөвлөх), (зорилго), (эрэх хайх), (итгэх), (төсөвлөх), (үнэлэх), (тооцоолох), (стратегий), (ирээдүй), (боломжит байдал), (таамаглах), (байх) зэрэг ирээдүй цагт хамааралтай үгсээр илэрхийлэгдэнэ.

Уг урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн Компанийн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, эдийн засгийн нөхцөл байдалд тулгуурлан гарсан одоогийн үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Зарим нэг тодорхойгүй болон урьдчилсан харах боломжгүй нөхцөл байдал нь компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх магадлалтай. Эдгээр хүчин зүйлд материаллаг байдлаас хамааран зах зээлийн үнэ, хайгуул болон олборлолтын үр дүн, санхүүжилтийн нөхцөл байдал болон ерөнхий эдийн засаг, зах зээл, бизнесийн нөхцөл байдлууд орно. Компанийн урьдчилсан таамаглал нь энэхүү мэдэгдлээр илэрхийлэгдэж буй хөрөнгө оруулагчдад анхааруулах мэдэгдэл юм.

Дээрх урьдчилсан таамаглал дахь мэдээллээс гадна энэхүү танилцуулгад: хайгуулын судалгааны үр дүн, нөөцийн тайлангийн үр дүн, шинэ эрдсийн нөөцийг тодорхойлох, баялгийг нөөцөд шилжүүлэх, нэмэлт хөрөнгө оруулалт татах, ирээдүйн санхүүжилт, хөрөнгийн зардал болон зардлууд, үүнд төсөвлөсөн зардлууд, Компанийн байгаль орчин, аюулгүй ажиллагаа болон бусад Хөндийн төслийн хөгжүүлэлттэй холбоотой тусгай зөвшөөрлийн нөхцөлүүд, үнэт металлын үнийн төсөөлөл, тусгай зөвшөөрлийн хүсэлт, авах тухай мэдээллийг агуулсан. Урьдчилсан таамаглал нь төсөөлөл болон тооцоололд тулгуурласан бөгөөд дээрх мэдээлэл, мэдэгдлүүд нь үндэслэлтэй гэж үзэж байгаа боловч бизнес, эдийн засаг болон өрсөлдөх чадвартай холбоотой тодорхойгүй, тооцоологдоогүй байдлыг үүсгэх боломжтой. Тодорхой болон тодорхойгүй байдал, үр дүнд нь энэхүү урьдчилсан таамаглалд тодорхойлсноос гадна өөрчлөгдөн, материаллаг өөрчлөлт орох боломжтой. Энэхүү хүчин зүйлд алт болон бусад эрдсийн бүтээгдэхүүний үнэ, Компани ирээдүйд хөрөнгө босгон бизнесийг үргэлжлүүлэх чадвар, засгийн газар болон захиргааны байгууллагын хууль тогтоомжийн өөрчлөлт, татварын орчин, Монгол улс дахь эдийн засаг, улс төрийн нөхцөл байдал, Компанийн нөөцийн тодорхойлох чадвар, эрдсийн агуулга, Хөндий төслийн геологи, судлын структур, ашиглалт болон хөгжүүлэлттэй холбоотой эрсдэлүүд, мөн хайгуул, олборлолттой холбоотой эрсдэлүүд үүнд шаардлагатай тусгай зөвшөөрлийг авах боломж, хангамж болон техник тоног төхөөрөмжийг хангах чадвар зэрэг багтана. Дээрх тодорхойгүй, тооцоологдоогүй нөхцөл байдал, хүчин зүйлс нь Компанийн үйл ажиллагаа, материаллаг байдалд нөлөөлөх, энэхүү болон бусад урьдчилсан таамаглалд тусгагдаагүй байх магадлалтай.

Уншигчдад анхааруулахад энэхүү урьдчилсан таамаглал дахь мэдээлэл нь Компанийн ирээдүйн үйл ажиллагааны баталгаа болохгүй. Эдгээр мэдэгдэл, мэдээлэл нь ирээдүйн үйл ажиллагаанаас шалтгаалан, тодорхойгүй байдал болон эрсдэлүүдээс шалтгаалан өөрчлөгдөх магадлалтай. Дээр дурдсан эрсдэлүүдэд алтны үнийн хэлбэлзэл, хайгуулын боломж, нөөцийн тодорхойгүй байдал, эрдсийн агуулга болон металл авалтын тооцоолол, хайгуул болон хөгжүүлэлтийн төлөвлөгөө саатах, санхүүжилт саатах, шаардлагатай тусгай зөвшөөрөл саатах, ордуудын эдийн засгийн тооцоолол буурах, хайгуул болон хөгжүүлэлтийн зардал, уул уурхайн салбарын өрсөлдөх чадвар, голлох удирдах албан тушаалтан, ажилтантай холбоотой эрсдэл, COVID-19-өөс үүсэх нөлөөлөл, маргаан, засгийн газар, хууль эрхзүйн байдалтай холбоотой өөрчлөлтүүдээс үүсэх зардлын өсөлт, байгаль орчны зардал, эрсдэл, гэмтэл болон хөдөлмөртэй холбоотой маргаан гарах зэрэг багтах боловч үүгээр хязгаарлагдахгүй. Дээрх эрсдэлүүд гарч, компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх тохиолдолд энэхүү урьдчилсан таамаглал, мэдэгдэлд тусгагдсанаас өөрөөр нөлөөлөх, материаллаг өөрчлөлт гарах боломжтой. Компанийн жилийн тайлан дахь эрсдэлийн хүчин зүйлтэй www.erdene.com-оос 2019 оны 3 сарын 27-нд тайлагнаснаар, эсвэл www.sedar.com-д тайлагнаснаар танилцаж болно. Компани хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд ирээдүйд энэхүү урьдчилсан таамаглалтай холбоотой мэдээ мэдээллийг шинэчлэх үүрэг хүлээхгүй.

Петер Далтон (Peter Dalton) нь Компанийн Ерөнхий геологич (Nova Scotia) бөгөөд NI 43-101-т заасан мэргэшсэн этгээд ба энэ танилцуулгад багтсан техникийн мэдээллийг Эрдэнэ Ресурсийн өмнөөс хянан баталгаажуулсан болно. Бүх валютын нэгж нь өөрөөр заагаагүй тохиолдолд Канад доллараар тайлагнагдсан.



СТОУС бус санхүүгийн арга хэмжээ

Компани нь энэхүү танилцуулгад хүү, татвар, элэгдэл хорогдлын өмнөх орлого (EBITDA), анхан шатны хөрөнгө оруулалт, нийт бэлэн мөнгөн зардал, алтны нэгжийн өртөг, татварын түвшин зэрэг СТОУС-ын дагуу хүлээн зөвшөөрөгдөөгүй эсвэл СТОУС-ын стандартын тайлбаргүй мэдээллийг агуулсан болно. Иймээс бусад байгууллагын мэдээлсэн ижил төстэй мэдээлэлтэй харьцуулахад хүндрэл үүсэх боломжтой. Эдгээр арга хэмжээнүүд нь нэмэлт мэдээллийг өгөх зорилготой бөгөөд СТОУС-ын дагуу бэлтгэгдсэн арга хэмжээнүүдийг тусгаарлан, эсвэл орлуулах байдлаар авч үзэхгүй байхыг анхааруулж байна.

Нийт мөнгөн зардал ба нэг унцад ногдох нийт мөнгөн зардал

Нийт мөнгөн зардал нь үйлдвэрлэлийн өртгийг тусгасан. Эцсийн ТЭЗҮ-д тусгагдсан нийт мөнгөн зардалд: олборлолт, баяжуулалт, ус дахин боловсруулах зардал, ерөнхий болон захиргааны зардал, уурхайн гадна зардал, боловсруулалтын зардал, тээвэрлэлтийн зардал болон роялти зардлууд багтсан. Нэг унцад ногдох нийт мөнгөн зардлыг худалдах боломжтой алтны унцад хувааж тооцоолно.

Нийт нэгжийн өртөг ба нэг унцад ногдох нийт нэгжийн өртөг

Эцсийн ТЭЗҮ-д танилцуулсан нийт нэгжийн өртөг ("AISC") –т: нийт мөнгөн зардал, ашиглалтын үеийн хөрөнгө оруулалт, тэлэлтийн хөрөнгө оруулалт, хаалтын үеийн зардлууд багтах боловч ерөнхий болон захиргааны зардал, үлдэх өртгийг хасаж тооцсон. Нэг унцад ногдох нийт нэгжийн өртгийг тооцохдоо нийт нэгжийн өртгийг худалдах боломжтой алтны унцад хувааж тооцоолно.

Үйлдвэрлэлийн нөөцийн мэдэгдэл

1. Ашигт малтмалын нөөцийн тооцоолол нь 2020 оны 07-р сарын 01-ээс хүчин төгөлдөр болсон. Тооцооллыг Auralia Mining Consulting-ийн захирал, Мэргэшсэн этгээд Антони Кийрс ("Mr. Anthony Keers") боловсруулсан.
2. Ашигт малтмалын нөөцийн тооцооллыг 2014 оны Канадын Уул уурхай, Металлург болон Газрын тосны дээд сургууль (CIM) Тодорхойлолтын Стандарт (2014 CIM Тодорхойлолтын Стандарт) болон 2003 оны CIM Шилдэг Практик Удирдамжийн дагуу бэлтгэсэн.
3. Нөөцийг ил уурхайн аргаар олборлоно гэж тооцоолсон
4. Хаягдал болон хүдрийн захын хязгаарыг моделийн блок бүрийн борлуулалтын цэвэр ашгийн төлбөрт тулгуурлан тооцсон. БЦАТ-ийг уурхайн бус алдагдал, тээвэрлэлт, хайлуулах болон цэвэршүүлэх зардлуудад тулгуурлан тооцоолсон.
5. Нөөцийг тооцоолохдоо нэг унц алтны үнэ \$1,400 ам.доллар төсөөлөл дээр үндэслэсэн.
6. Ашигт Малтмалын Нөөцөд 9% бохирдолт болон 1% алдагдал багтсан






ЭРДЭНЭ БА МОНГОЛ

Алтны үндсэн ордын олборлолт нэмэгдэж байна

Олборлолтын шат руу хурдацтай хөгжүүлэх нь



Гурван орд, хэтийн төлөв бүхий талбай, хайгуул хязгаарлагдмал хийгдсэн бүс Олборлолтын шат руу хурдацтай хөгжүүлэх нь

- Алт, зэсийн ордуудыг нээн илрүүлсэн
 - Зуун Мод – 2011
 - Алтан Нар – 2015
 - Баян Хөндий – 2018
- Өнгөрсөн 10 жилийн хугацаанд Монголын баруун өмнөд хэсэгт төвлөрөн ажилласан
 - 542,000 га тусгай зөвшөөрөл бүхий талбай
 - Бүс нутаг дахь хамгийн том хувийн мэдээллийн сан
 - Хиймэл дагуулын болон астер мэдээллийн тайлал хийсэн
 - 4,000,000 га талбайд геохимийн шинжилгээ хийсэн
- Уул уурхайн бүсийн дэд бүтэц сайжирч байна



ХӨНДИЙ АЛТНЫ ТӨСӨЛ


Гурван орд, хэтийн төлөв бүхий талбай,
хязгаарлагдмал судлагдсан бүс
Олборлолтын шат руу хурдацтай хөгжүүлэх нь



ХӨНДИЙ АЛТНЫ ДҮҮРЭГ

Өсөн нэмэгдэж буй эрдсийн нөөц

Олборлолтын шат руу хурдацтай хөгжүүлэх нь



Алтан Нарын ил уурхайн нөөцийт 0.7 г/т, ил уурхайгаас гүнд буй нөөцийн захын агуулгыг 1.4 г/т AuEq байхаар тооцоолсон. Баян Хөндийн захын агуулгыг 2018 онд 0.6 г/т, 2019 онд 0.55 байхаар тооцоолсон.

БАЯН ХӨНДИЙ АЛТНЫ ОРД

Газрын дөт гүн дэх өндөр агуулга бүхий алтны нээлт

Хар Морь талбай

Хээрийн анги

Мидфийлд

Страйкер

Алтан Толгой

**БАЯН ХӨНДИЙ
АЛТНЫ ОРД**

Бид бүс нутгийн томоохон алт үйлдвэрлэгч болох зорилготойгоор Баян Хөндий орд дээр түшиглэн алтны өндөр агуулга бүхий ил уурхайг олборлож жилд 60,000 унц алт үйлдвэрлэхийн зэрэгцээ хайгуул, хөрөнгө оруулалтад тулгуурлан үйл ажиллагаагаа өргөжүүлнэ.

НӨӨЦИЙН ТООЦООЛОЛ СУУРЬ СУДАЛГААТАЙ ТОХИРЧ БАЙНА

Олборлолтын шат уруу хурдацтай хөгжүүлэх нь



БАЯН ХӨНДИЙ ОРД

ГЕОЛОГИЙН НӨӨЦ

Захын агуулга	Ангилал	Хэмжээ (Сая. т)	Агуулга (Au г/т)	Алт (мян.унц)
0.4	Баттай	1.7	3.15	176
	Бодит	4.6	2.45	364
	Баттай & Бодит	6.4	2.64	540
0.55	Баттай	1.4	3.77	171
	Бодит	3.7	2.93	350
	Баттай & Бодит	5.1	3.16	521
1.0	Баттай	0.7	7.31	153
	Бодит	1.7	5.56	304
	Баттай & Бодит	2.3	6.05	457
	Боломжит	0.4	6.83	93

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН НӨӨЦ

- Алт авалт 2.6% өссөн нь урьдчилсан ТЭЗҮ дээр танилцуулсан блок агуулгыг үйлдвэр тэжээх агуулга болгон шинэчилсэн.
- Хүдрийн хэмжээ 3% буурсан нь уурхайн загварчлалд өөрчлөлт орж, захын агуулга нэмэгдэн, дундаж үйлдвэр тэжээх агуулга нэмэгдсэн.
- Хөрс хуулалтын харьцаа 8% буурсан нь геотехникийн параметрууд сайжран, материалын хөдөлгөөн 4.7 сая тонноор буурна

Ангилал	Нийт	Алтны агуулга	Агуулсан алт
	Сая тн	г/т Au	Мян унц
Батлагдсан үйлдвэрлэлийн нөөц	1.2	4.2	166
Магадалсан үйлдвэрлэлийн нөөц	2.2	3.5	244
Нийт үйлдвэрлэлийн нөөц	3.4	3.7	409

Тэмдэглэл


- Ашигт малтмалын нөөцийн тооцоолол нь 2020 оны 07-р сарын 01-аасхүчин төгөлдөр болсон. Тооцооллыг Мэргэшсэн этгээд Auriala Mining Consulting-ийн захирал, Мэргэшсэн этгээд Антони Кийрс ("Mr. Anthony Keers") боловсруулсан.
- Ашигт малтмалын нөөцийн Тооцооллыг 2014 оны Канадын Уул уурхай, Металлург болон Газрын тосны дээд сургууль (CIM) Тодорхойлолтын Стандарт (2014 CIM Тодорхойлолтын Стандарт) болон 2003 оны CIM Шилдэг Практик Удирдамжийн дагуу бэлтгэсэн.
- Нөөцийг ил уурхайн аргаар олборлоно гэж тооцоолсон
- Хаягдал болон хүдрийн захын хязгаарыг моделийн блок бүрийн борлуулалтын цэвэр ашгийн төлбөрт тулгуурлан тооцсон. БЦАТийг уурхайн бус алдагдал, тээвэрлэлт, хайлуулах болон цэвэршүүлэх зардлуудад тулгуурлан тооцоолсон.
- Нөөцийг тооцоолохдоо нэг унц алтны үнэ \$1,400 ам.доллар төсөөлөл дээр үндэслэсэн.
- Ашигт Малтмалын Нөөцөд 9% бохирдолт болон 1% алдагдал багтсан

Тэмдэглэл

- Геологийн нөөцийн тооцооллын тайланг Камерон Нортоны удирдлаган дор боловсруулав, тэрээр Tetra Tech-ийн орон тооны ажилтан бөгөөд мэргэшсэн геосудлаач юм. Ноён Нортон хэлэлцэж буй холбогдох ордын эрдэжилт болон ордын хэв маяг, хэлбэрийн талаар хангалттай туршлагатайгаас гадна CIM-ийн ил тод байдлын стандартад тодорхойлсон Мэргэшсэн этгээдийн шаардлага хангасан мэргэжилтэн юм.
- Дээрх хүснэгтэд тайлагнасан бүх нөөцийн тооцооллууд нь 2019 оны 4-р сарын 22-ны өдөр хүртэл гүйцэтгэсэн өрөмдөлгийн үр дүнд тулгуурласан. Нөөцийн тайлан нь нарийн өгөгдөл биш бөгөөд судалгааны үр дүн, байршил, хэлбэр болон тархац зэрэг хязгаарлагдмал мэдээлэлд тулгуурлан боловсруулагдсан. Дээр өгөгдсөн өгөгдлүүд нь тооцооллын харьцангуй байдалд тулгуурласан бүхэл тоогоор тоймлосон болно. Үүнээс шалтгаалсан тооцооллын зөрүү гарах магадлалтай.
- Нөөцийн тайланг хуурай, газар дээрх төлөвт нь үндэслэн тайлагнасан.
- Нөөцийн тайлангийн захын агуулгыг 0.55 г/т байхаар тооцсон. Эдгээр захын агуулгын тооцоог Tetra Tech нь ил уурхайн аргаар боловсруулах төсөөлөлд тулгуурлан, алтыг нэг унц нь US\$1,350, ил уурхайн зардал нэг тонн тутамд US\$6 , нэг тонн хүдрийг боловсруулах зардал US\$16, ерөнхий ба захиргааны зардал нэг тонн тутамд US\$5 доллар, металл авалт 0.95% байх төсөөлөлд тулгуурлан боловсруулсан.
- Нөөцийн тайлан нь алтны үнэ \$2,000 ам.доллар байхад оновчтой уурхайн ханын хязгаараар тооцоологдсон бөгөөд эдийн засгийн өгөөж нь дээрх тооцооллууд дээр үндэслэсэн.
- Нөөцийн тайланд эрдэжсэн бүсийн дундаж нягтаршил 2.66 т/м3 байхаар төсөөлсөн.
- Дээрх геологийн нөөц нь эдийн засгийн тооцоололд ороогүй бөгөөд эдийн засгийн хувьд үр ашгитай эсэхийг тооцоогүй болно.
- Баттай ба бодит нөөц нь эдийн засгийн тооцоололд багтахгүй. Боломжит нөөцийг техник эдийн засгийн тооцоололд нөөц хэмээн багтаахад геологи, эдийн засгийн хувьд хүндрэлтэй. Үйлдвэрлэлийн нөөцөд багтаахгүй.

Ил алтны уурхайн дундаж агуулгаас гурав дахин өндөр агуулга
Олборлолтын шат руу хурдацтай хөгжүүлэх нь

Алтны агуулга (г/т)



Баян Хөндий ордын ашиглалтын хугацааны дундаж хүдрийн агуулга ²
3.73 г/т

Дэлхийн ил алтны уурхайдын дундаж агуулга ¹
1.03 г/т

1. Эх сурвалж: Wood MacKenzie, Дэлхийн алтны ордын зардлын мэдээллийн сан, 2018.08
 2. Урьдчилсан ТЭЗҮ-ийн тухай мэдээлэлтэй 2019 оны 10-р сарын 21-ний хэвлэлийн мэдээнээс танилцана уу.



5 ЖИЛ

ОРДЫН НЭЭЛТЭЭС ЭЦСИЙН ТЭЗҮ-ИЙГ
БОЛОВСРУУЛАХАД ЗАРЦУУЛСАН
ХУГАЦАА

ОРДЫН НЭЭЛТ
2015.05

АШЭЗТ: RPMGlobal
2018.12

У-ТЭЗҮ: Tetra Tech Inc
2019.10

Э-ТЭЗҮ: Roma Group
2020.07



БАЯН ХӨНДИЙ АЛТНЫ ТӨСӨЛ

Эцсийн ТЭЗҮ-ийн судалгааны зөвлөх байгууллагууд

Олборлолтын шат руу хурдацтай хөгжүүлэх нь



Хонг Конгийн Хөрөнгийн Биржид бүртгэлтэй байгалийн нөөц, бизнесийн үнэлгээ, эрсдэлийн чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг мэргэжлийн зөвлөх байгууллага

Э-ТЭЗҮ Хамрах хүрээ: Судалгааны тэргүүлэгч, нөөцийн геотек ба гидро, санхүүгийн загварчлал



Оюу Толгойн төсөлд хамтран ажиллаж байсан туршлагатай, Австралийн уурхайн ашиглалтын үеийн хаягдлын удирдлага, загварчлал ба ашиглалт

Э-ТЭЗҮ хамрах хүрээ: Хаягдлын байгууламжийн загварчлал ба хаалт



Ванкуверт төвтэй металлургийн шинжилгээ, тайлал, загварчлалын зөвлөх

Э-ТЭЗҮ хамрах хүрээ: Металлург



Ausenco-ийн үйл ажиллагаанаас үүдэн, загварчлал инженерийн иж бүрэн үйлчилгээ үзүүлдэг Филиппинд төвтэй зөвлөх байгууллага

Э-ТЭЗҮ хамрах хүрээ: Боловсруулах үйлдвэрийн загварчлал, инжернерчлэл



Перт-д төвтэй уул уурхайн инженерчлэл, нөөцийн загварчлал

Э-ТЭЗҮ хамрах хүрээ: Уурхайн загварчлал (уурхайн хаалт багтсан) ба ашигт малтмалын нөөцийн тайлан



Улаанбаатарт төвтэй уул уурхай, санхүүгийн зөвлөгөө үзүүлдэг байгууллага


Э-ТЭЗҮ хамрах хүрээ: Уурхайн дотоод зураг төсөл, боловсруулах үйлдвэрээс бусад дэд бүтэц, худалдан авалт ба зураг төслийн зөвшөөрөл



ECO TRADE LLC

Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ, удирдлагын Монгол ба олон улсын консорциум; Монгол болон дэлхийн таваарын зах зээл, бүтээгдэхүүн болон мөчлөгийн өндөр туршлагатай

Э-ТЭЗҮ хамрах хүрээ: Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ, гидрогеологи



АНХАН ШАТНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БАГА БӨГӨӨД ЭДИЙН ЗАСГИЙН ӨГӨӨЖ ӨНДӨР

Олборлолтын шат руу хурдацтай хөгжүүлэх нь

Татварын дараах NPV

\$ 100 сая ам.дол

@5% хорогдуулалт & алтны үнэ \$1,400

Татварын дараах IRR

42%

Эргэн төлөгдөх хугацаа 1.9 жил

Нэг унц алтны нийт нэгжийн өртөг (AISC)

\$ 733 ам.дол/унц

Анхан шатны хөрөнгө оруулалт

\$ 59 сая ам.дол

Хүдрийн дундаж агуулга

3.7 г/т

Дундаж металл авалт 93%

Жилд үйлдвэрлэх алтны дундаж хэмжээ


63,600 унц

НАРИЙВЧИЛСАН ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН
ҮНДЭСЛЭЛИЙН ОНЦЛОХ МЭДЭЭЛЭЛ

АЛТНЫ ҮНИЙН ХАМААРАЛ: АЛТНЫ ҮНИЙН ӨСӨЛТ ӨГӨӨЖИД ХЭРХЭН НӨЛӨӨЛӨХ ВЭ?


Олборлолтын шат руу хурдацтай хөгжүүлэх нь

Өнөөгийн үнэ цэн (NPV)



Э-ТЭЗҮ суурь судалгаа Өнөөгийн алтны үнэ

Дотоод өгөөжийн түвшин (IRR)



Э-ТЭЗҮ суурь судалгаа Өнөөгийн алтны үнэ

БАЯН ХӨНДИЙ ТӨСЛИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН НӨӨЦ


АНГИЛАЛ	Нийт	Алтны агуулга	Агуулсан алт
	Сая тонн	г/т Au	Мян.унц
Батлагдсан үйлдвэрлэлийн нөөц	1.2	4.2	166
Магадалсан үйлдвэрлэлийн нөөц	2.2	3.5	244
Нийт нөөц	3.4	3.7	409

*Эрдсийн нөөцийн тэмдэглэлтэй 3-р хуудас дахь СТОУС бус арга хэмжээний тухай мэдэгдэл хэсгээс танилцана уу.

БАЯН ХӨНДИЙ АЛТНЫ ОРД

Газрын дөт гүн дэх алтны нөөц

Олборлолтын шат руу хурдацтай хөгжүүлэх нь




БАЯН ХӨНДИЙ ОРД


Хүдрийн агуулга 3.7 г/т
 Хөрс хуулалтын харьцаа 9.1 т:т
 Үйлдвэр тэжээх хүдэр 1,800 т/өдөр

Дундаж металл авалт 93%
 Дундаж олборлолт 63,700 унц/жил
 Төслийн ашиглалтын хугацаа 8 жил

ОЛБОРЛОЛТЫН ХУВААРЬ


(Дунджаар жилд 64,000 унц, 5 дахь жилд хамгийн дээд хэмжээнд буюу 79,000 унц хүрнэ)





БАЯН ХӨНДИЙ АЛТНЫ ТӨСӨЛ
Төслийн Загварчлал

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ЗАДАРГАА



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	УАХ \$ сая	\$/унц	\$/т
Олборлолтын зардал	\$133	\$350	\$39
Боловсруулалтын зардал	\$96	\$252	\$28
Ерөнхий & захиргааны зардал	\$13	\$33	\$4
Нийт үйл ажиллагааны зардал	\$242	\$635	\$71
Нөөц ашигласны төлбөр & бусад зардал	\$33	\$86	\$10
Ашиглалтын үеийн хөрөнгө оруулалт ба уурхайн хаалтын зардал	\$5	\$12	\$1
Алт үйлдвэрлэх нэгжийн өртөг	\$279	\$733	\$82

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗАРДЛЫН ЗАДАРГАА



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗАРДЛУУД \$ сая

Баяжуулах үйлдвэр	\$24
Үйлдвэрээс бусад дэд бүтэц	\$10
Байр, орон сууц	\$2
Барилга байгууламжийн шууд бус зардал	\$6
Инженерчлэл & бусад	\$4

Бүтээн байгуулалтын зардал \$46

Олборлолтын өмнөх зардлууд	\$5
Хөдөлгөөнт тоног төхөөрөмжүүд	\$1
Эхний дүүргэлт	\$1
Болзошгүй зардлууд	\$5

Нийт \$59

Голлох үе шатууд

	2020		2021				2022	
	Q3	Q4	Q1	Q2	Q3	Q4	Q1	Q2
Бүтээн байгуулалтанд шаардлагатай тусгай зөвшөөрлүүд	✓							
Бүтээн байгуулалтын бааз байгуулах		✓						
Баяжуулах үйлдвэрийн нарийвчилсан зураг төсөл	✓							
Үйлдвэрээс бусад дэд бүтцийн нарийвчилсан инженерчлэл	✓							
Газар шорооны ажил эхлэх		✓						
Иргэний барилга			✓					
Баяжуулах үйлдвэрийн бүтэц				✓				
Баяжуулах үйлдвэрийн тоног төхөрөөмж нийлүүлэлт				✓				
Баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалт			✓					
Үйлдвэрээс бусад дэд бүтцийн бүтээн байгуулалт			✓					
Улсын Комиссын зөвшөөрөл						✓		
Эхний хүдэр боловсруулалт						✓		
Анхны алт олборлолт							✓	

✓ Гүйцэтгэх хугацаа

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛҮҮДИЙН ҮЙЛ ЯВЦ

Олборлолтын шат руу хурдацтай хөгжүүлэх нь



ХӨНДИЙ АЛТНЫ ТӨСӨЛ

Хөх тэнгэрийн орон

Олборлолтын шат руу хурдацтай хөгжүүлэх нь



БАЯН ХӨНДИЙ:

Ил уурхайтай залгаа орших тэлэх боломжтой бүсүүд

Олборлолтын шат руу хурдацтай хөгжүүлэх нь

- Баттай ба Бодитой нөөц: 3.16 г/т алтны агуулга бүхий 521,000 унц
- Боломжтой нөөц: 3.68 г/т алтны агуулга бүхий 103,000 унц
- Мидфийлд, баруун урд бүсэд газрын дөт гүнд маш өндөр агуулга илэрсэн
- Уурхайн хананаас урд болон хойд зүгт нөөцийг тэлэх боломжтой



БАЯН ХӨНДИЙ ТЭЛЭЛТ БОЛОН ӨРӨМДЛӨГИЙН БҮС

- Q2-2020 өрөмдлөгийн бүс
- Бага агуулгатай бүс
- Өндөр агуулгатай бүс
- Хайгуул-тэлэлтийн бүс

500м



ӨНДӨР АГУУЛГА БҮХИЙ ОГТЛОЛУУД

Олборлолтын шат руу хурдацтай хөгжүүлэх нь


Q2 2020 өрөмдлөгөөр газрын дөт гүнд хэд хэдэн өндөр агуулга бүхий бүсийг нээн илрүүлсэн

ВКD-292
15м 29 г/т Au

ВКD-288
5.5м 125.9 г/т Au

ВКD-274
15.1м 25.59 г/т Au

БАЯН ХӨНДИЙ УУРХАЙ
План зураглал



 Өндөр агуулга бүхий бүс

 Ил уурхайн төлөвлөсөн хана

0

метр

300

ХАР МОРЬ ТАЛБАЙ


Q2 2020 суваг малталтаар 8.8 г/т алтны агуулга бүхий 6 метр, 14 г/т алтны агуулга бүхий 4 метр илрүүлсэн



БАЯН ХӨНДИЙ

Тусгай зөвшөөрлийн талбайд тодорхойлсон хэтийн төлөв бүхий бүсүүд

Олборлолтын шат руу хурдацтай хөгжүүлэх нь




БАЯН ХӨНДИЙ АЛТНЫ ОРД:

Q2 2020 тэлэлтийн өрөмдлөгийн хөтөлбөр хэрэгжүүлсэн талбай

Зүүн урд Мидфийлд бүс

Баруун урд Страйкер бүс



Чулуулгийн дээж

- ▲ > 10 г/т
- ▲ > 5-10 г/т
- ▲ 1-5 г/т
- Цооног
- Структур


1570 (max)

Gold in Soil (ppb)
6

ХАР МОРЬ ТАЛБАЙ

Q2-2020 Хайгуулын үр дүнгүүд

План зураглал



KMT-01




KMT-02



KMT-03



45 g/t GOLD OVER 7 METRES INTERSECTION DEMONSTRATES THE POTENTIAL OF ALTAN NAR'S 5.6 KM LONG MINERALIZED TREND



2019 оны 1-р улирлын хайгуул хийгдэж байгаагүй бүсээс илэрсэн үр дүн

ЭРДЭНИЙН МОНГОЛ ДАХЬ ҮЙЛ АЖИЛЛАГАА



Хууль эрхзүй болон нийгмийн хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн

Олборлолтын шат уруу хурдацтай хөгжүүлэх нь

1997 оноос хойш Монгол улсад ажиллаж буй хамт олон



Европын Сэргээн босголт, Хөгжлийн Банк ("EBRD")-тай стратегийн хөрөнгө оруулалт хамтран хийсэн



МХБ болон TSX-д давхар бүртгүүлсэн анхны компани, 6,000 гаруй Монгол хувьцаа эзэмшигчидтэй



15 жилийн турш орон нутаг, байгаль орчны хөгжилд хөрөнгө оруулалт хийж буй



ХӨРӨНГИЙН БҮТЭЦ

Хувьцаа эзэмшигчдийн дэмжлэг
Олборлолтын шат руу хурдацтай хөгжүүлэх нь

Хөрөнгийн Бүтэц (2020.08.13)

	Кан.дол	Ам.дол
Хувьцааны ханш	\$0.54	\$0.41
Ханшийн хэлбэлзэл (52 долоо хоног)	\$0.13-\$0.71	\$0.09-\$0.54
Зах зээлийн үнэлгээ	\$128.2 М	\$97.1 М
Нийт хувьцаа	237.4 сая	
Опцион	11.5 сая / Орлого: \$4.9 сая	
Варрант	75.7 сая / Орлого: \$41.0 сая	
ИОХЭ	4.5 сая	
Бүрэн хорогдуулсан хувьцаа	359.7 сая	
Бэлэн мөнгө	\$20.5 сая	\$15.5 сая
Өр төлбөр	\$6.9 сая	\$5.0 сая

1. ЕСБХБ-наас \$5 сая ам.долларын хөрвөх боломжит зээлийг хүлээн авсан. Зээлийг хөрвүүлэх нөхцөлөөр хөрвүүлэлт хийсэн тохиолдолд компанийн 31 сая энгийн хувьцаанд хөрвөнө.

Хөрөнгийн биржийн тикер: TSX: ERD | MSE: ERDN

Хувьцаа эзэмшигчид

Олон нийт



44%



Монгол хувьцаа
эзэмшигчид

6%

Эрдэнэ Ресурсийн
удирдлага, ТУЗ



8%

Тек Ресурс Лимитед

Teck

7%

Хөрөнгө оруулалтын сангууд,
хувийн сангууд



35%

ЭРДЭНЭ РЕСУРСД ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ШАЛТГААНУУД



- **Алтны агуулга маш өндөр, илээр олборлох боломжит уурхайн** бүтээн байгуулалтыг 2020 оны эцэст эхлүүлэхээр төлөвлөсөн
- **Бага өртөг, өндөр өгөөж бүхий төслийн олборлолтыг** 2021 оны эцэст эхлүүлж, жилд 60,000 унц алт олборлохоор төлөвлөсөн
- **Дүүргийг нээсэн анхдагч компанийн өрсөлдөх чадвар**
- Өнгөрсөн 10 жилийн хугацаанд өндөр агуулга бүхий хэд хэдэн талбайг тодорхойлж, гурван ордыг нээн илрүүлсэн **техникийн чадавхитай баг**
- Монгол дахь төслүүдийг санхүүжүүлэх, дэлхийн түвшний түншүүд, зохицуулагч байгууллагатай хамтрах, харилцах чадвараа баталсан **компанийн хөгжүүлэлт**, туршлагатай баг хамт олон
- **ТУЗ ба удирдлага** нь компанийн хувьцааг эзэмшдэг
- Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк болон стратегийн хөрөнгө оруулагчид, олон нийтээс бүтсэн **урт хугацааны хувьцаа эзэмшигчидтэй**
- Монголын Хөрөнгийн Биржид давхар бүртгэгдсэн анхны компани бөгөөд сүүлийн +10 жил олон нийттэй хамтран ажиллаж, **нийгмийн хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн байгууллага**



ҮНЭ ЦЭНИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ХҮЛЭЭЛТҮҮД

- ❖ **Баян Хөндийн** геологийн болон үйлдвэрлэлийн нөөцийг нэмэгдүүлэх хайгуулын хөтөлбөр – 2020 ¾-р улирал
- ❖ **Хар Морь** хайгуулын өрөмдлөгийн хөтөлбөр – 2020 3-р улирал
- ❖ **Алтан Нар** өрөмдлөгийн хөтөлбөр – 2020 4-р улирал
- ❖ **Бүтээн байгуулалтын** бэлтгэл ажлыг эхлүүлэх - 2020 оны эцэст
- ❖ **Төслийн санхүүжилтийг** татан төвлөрүүлэх – 2020 оны эцэст
- ❖ **Бүтээн байгуулалтын** ажлыг эхлүүлэх – 2021 он
- ❖ Бүтээн байгуулалтын ажил эхэлснээс 18 сарын дотор **олборлолт** эхлүүлнэ.



@ErdeneRes



@ErdeneResource



Erdene Resource Development Corp.



www.erdene.com